

## “АЛДАР, НЭР” ГЭХ ХОЁР ҮГИЙН УТГЫН ХҮРЭЭГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Ц.Өнөрбаян, Р.Сарангэрэл, МУБИС

### Abstract

The paper presents the analysis of the explanation of the meanings of the word of “aldar, ner”. A word meaning is complex, so that the terms, phrases and sources are the main unit of features of mindset of Mongolians. Language is responsible to communicate, inform, and affect as well as to create the knowledge of the real world in which the human reaches it. Therefore, we intended to describe the meanings of the compound word of “Алдар, нэр” – “fame” or “honor” or “prestige”, and made an attempt to explain the structure of these words from the semantics. Meaning of the word and evolution of the value, idioms from the exact meaning and compounds are related to the nation’s spirit.

The referential meanings of the word in Mongolian language are formed by the creation of one concept from the other, by the conceptual relationships, by the abstraction of similar features, by the logical relations, and by the use of the “NER” concept. Therefore, it was created by ideal concept of cognition ‘name is physic, name is ethics’. Otherwise, formation of the referential meaning of these words is based on the analogy and association of conceptual relationships creates the knowledge of how complex concepts can be recognized and applied, and more specifically, it creates condition to form new stable expressions. Therefore, these words created by complex concepts have a more stable position, but ‘name’ words that express the main meanings and have important features have been commonly created.

### Түлхүүр үг

Алдар, нэр, хоршоо үг, хэлц хэллэг, утга, утгын хүрээ, танихуйн хэл шинжлэл

Монгол хэлэнд хоёр үг бие биеэ захирахгүй, харилцан тэгш эрхтэй зэрэгцэн холбогдож бүтсэн нийлмэл үг байдаг. Энэ нийлмэл үгийг “хоршоо үг” гэж судалгааны бүтээлүүдэд тодорхойлсон боловч судлаачид хоршсон нийлмэл үг, зэрэгцээ үг, зэрэгцсэн нийлмэл үг, зэрэгцсэн холбоо үг, хос нэрлэлт, хос зэрэгцэл, холбон бэлгэлсэн үг гэх мэтээр нэрлэж ирсэн байна. “Нийлмэл нэрийн бүрэлдэхүүнд багтсан үгс нь нэг ухагдахууныг зааж, улмаар өгүүлбэрийн нэг гишүүн болдог онцлогтой. Монгол хэл шинжлэлд ерийн хоршсон нийлмэл үг, хоршоо нэр үг гэсэн нэр томъёог хэрэглэдэг (Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал, 1987, 33).

Хоршоо үгийг монгол хэлний эртний үзэгдэл болохыг анх Түмэдийн Галсан “Монгол үсгийн бүгд тайлбар бичиг” (Галсан, 1981, 108) хэмээх бүтээлдээ дурдсан байдаг. Монгол хэлний хоршоо үгийн бүтэц, хэл зүйн шинж, хэв маяг, үүргийг дотоод, гадаадын эрдэмтэд судалж, “хоршоо үг гэдэг нь хоёр ба түүнээс дээш үгээс бүтсэн цогц шинжтэй, тухайн үгсийнхээ аль алины утгыг багтаасан тогтвортой, дан үгийн утгаас илүү ерөнхий хийсвэр ухагдахуун илэрхийлдэг нэгж” хэмээн тодорхойлсон байдаг. Харин бид судалгааны ажилдаа “Нэгэн цогц утга илэрхийлж, үгийн сан, өгүүлбэр зүйн хувьд нэг

нэгж болж буй үгсийн аймгийн болон утгын нэг зүйлчлэлийн хоёр үг зэрэгцэх харьцаагаар холбогдон бүтэх нийлмэл үгийг хоршоо үг гэнэ” (Сарангэрэл, 2016, 155) гэж үзсэн.

Хүнтөрөлхтөн юмс үзэгдлийг танин мэдэх, түүнийг бусдаас ялган үзэх, нэрлэж тэмдэглэх нь тухайн угсаатны сэтгэлгээтэй холбоотой. Иймээс бид үгийн утгыг тайлбарлахдаа үндэстний ахуй соёл, зан заншил, хүний ердийн амьдралтай холбоотой танихуйн үйл ажиллагаанд чиглэсэн туршлага, ертөнцийг ухаарах, үнэлэх, хүлээж авах зэрэг хэлэнд шингэсэн мэдээллийг нягтлан үзэж утга хэрэглээ, соёл сэтгэлгээг тодруулж болно гэж үзэж байна. “Цогц ойлголт бол бодит ертөнцийн юм, үзэгдлийн хувь хүний танихуйн туршлагад суурилсан тархин дахь тусгал, уг хүний тухайн юм үзэгдэлтэй холбоотой багц мэдлэг. Ухагдахуун юм үзэгдлийн зайлшгүй, гол шинжүүдийн нэгдэл бол цогц ойлголт гол бус шинжүүдийг ч агуулна. Утга нь утгын тогтолцооны нэгж бол цогц ойлголт нь сэтгэлгээний хүрээнд авч үзэх нэгж юм. Цогц ойлголтын бүтэц танихуйн шинжүүдээс үүсэх цөм ба захын гэсэн ялгаатай. Цөмөөс зах руугаа агуулга нь хийсвэрлэгдэнэ” (Нансалмаа, 2014, 71). Энэ үүднээс монгол хэлний хоршоо үг үүсэх зүй тогтлыг харвал, нэгэн цогц ойлголтын хүрээнд монголчуудын ертөнцийг үзэх үзэл, ахуй соёл, сэтгэц мэдрэмж, сэтгэл хөдлөл, зан заншлыг

\* ✉ unurbayan@msue.edu.mn

илэрхийлсэн үгс утгын болоод хэрэглээний нэгэн зүйлчлэлийн хүрээнд хоршиж байгаа нь монголчуудын танин мэдэхүй, сэтгэлгээний хувьсал хөгжлийг харуулж байна. Тиймээс хэл нь ертөнцийн тухай мэдлэгийг тусган хэлний дүр зураг болгон буулгадаг. Иймээс л хэлний нэгжүүдийн утгыг судлах замаар танин мэдэж тайлбарлах боломжтой.

Танихуйн хэл шинжлэл нь цогц ойлголтыг илэрхийлэхдээ ухамсарт далд байгаа ойлголтуудыг биежүүлсэн нэгжүүдийн утгыг судалдаг. Хэлний нэгжүүдийн утгын холбоо харьцаанд тулгуурлан үндэстний сэтгэлгээний онцлогийг тайлбарлаж болно. Хэл нь харилцах, мэдээлэх, нөлөөлөх үүрэгтэйгээс гадна хүний хүртэж мэдэрсэн бодит ертөнцийн талаарх мэдлэгийг тусган авч хуримтлуулан хадгалж байдаг. Иймд бид “алдар нэр” гэх хоршоо үг болон алдар, нэр хэмээх үгстэй хорших нийлмэл үгийн утгын харьцааг тайлбарлаж, энэ хүрээний утгын гүн бүтцийн онцлогийг танихуйн хэл шинжлэлийн үүднээс судлахыг зорилоо.

## Үндсэн хэсэг

Тодорхой үгийн утга, түүний түүхэн хувьсал, бусад үгтэй цуваа цэгийн харьцаанд орсон нийлмэл үг хийгээд хэлц хэллэгүүд нь тухайн үндэстний сэтгэлгээтэй салшгүй холбоотой. Хүн болж төрсөн бүхэнд дуудах нэр өгдөг хүн төрөлхтний нийтлэг заншил байдаг бөгөөд харин “алдар” бол тухайн хүний хичээл зүтгэл, хөдөлмөр бүтээл, бусдын төлөө байгуулсан гавьяа зэргээс шалтгаалж дуудах нэрийн тодотгол болгон өгдөг цол хүндэтгэл юм.

“Нэр, алдар” хэмээх хоёр үг өөр өөр утга хэрэглээтэй, найруулгын ялгаатайг тодруулбал,

### 1. Тайлбар толь бичигт туссан үгийн утга

“Алдар” хэмээх үгийг монгол хэлний тайлбар толиудад - Аливаа сайн муу нэрийг алдар хэмээмүй (36 - тын толь.1966, х.26), Хүний оноосон нэр, Олонд алдаршиж дуурссан сайн нэр (Одонтог, Баттогс, 2013, х.25), Нэрийн хүндэтгэл, Олонд гарсан, дуурссан нэр, Үнэнгүй бөгөөтөл хуурам бадруулсан цуурхал (Цэвэл, 2013, х.28-29), Хүндэтгэл нэр, Гавьяа зүтгэл, авьяас чадвар, амжилтаараа олон түмэнд түгэж мандсан нэр (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, А-Г, ШУА, 2008, х.69-70), Нэр, алдар бие, алдар нэр, Гавьяа зүтгэл, авьяас чадвар, амжилтаараа олон түмэнд түгэж мандсан нэр (Монгол хэлний тайлбар толь, Монгол хэл соёл-1 Монсудар 2011,

х.33), Нэрийн хүндэтгэл, Нийгэм даяар танигдсан сайн нэр. (Nor9in, Man, Mu2ru2n. Monggol kelen-u2 toli. 1999, х.89), Хүндэтгэл нэр, Тухайн хүнийг төрөхөд өгсөн дуудах үг, Олон түмэнд үнэлэгдэх байдал (<https://mongoltoli.mn/dictionary/>), Харин “нэр” хэмээх үгийг - Хүн ба юмыг бусдаас ялгаж, нэг ба цөөн үгээр оноосон хэвшмэл тэмдэглэгээ (Одонтог, Баттогс, 2013, х.473-474), хэн юу гэсэн асуултад хариулах нэр, тухайн хүний үг нэр, хүнийг анх төрөхөд ногдуулан зүүлгэж дуудах үг, бас мал адгуусанд бий (Цэвэл, 2013, х.555-556), Юм үзэгдлийг үгээр ялган тэмдэглэсэн нь, Тухайн хүнийг төрөхөд нь өгсөн албан ёсны дуудах үг, Хүн, амьтан юм үзэгдэл хийгээд бодот тодорхой, ерөнхий хийсвэр аливаа ухагдахууныг заан илэрхийлэх үг (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, М-С, ШУА, 2008, х.1434-1435), Юм үзэгдлийг үгээр ялган тэмдэглэсэн нь, Хүн, амьтан юм үзэгдэл хийгээд бодот тодорхой, ерөнхий хийсвэр аливаа ухагдахууныг заан илэрхийлэх үг (Монгол хэлний тайлбар толь, Монгол хэл соёл-1 Монсудар. 2011, х.813-814), Юм үзэгдэл, хүн амьтныг ялган тэмдэглэсэн дуудлага, Нийгэм даяар гайхагдсан үнэлэлт (Nor9in, Man, Mu2ru2n. Monggol kelen-u2 toli. 1999, х.774), Юм үзэгдлийг ялган тэмдэглэсэн нь, Хүн амьтанд оноож дуудах үг, Алдар дуурсгал (<https://mongoltoli.mn/dictionary/>) гэж тайлбарлажээ.

### 2. Хоршоо үг үүсгэх байдал

Эндээс зөвхөн “нэр- хүнд оноож, ялгаж тэмдэглэсэн дуудлага, оноож дуудах үг”, харин “алдар - нэрийн хүндэтгэл бөгөөд олон түмэнд сайнаар үнэлэгдсэн, мандан бадруулсан нэр” гэсэн утгаас улбаалан хэрхэн нийлмэл үг, хэлц хэллэг үүссэнийг, мөн монгол үндэстний “өөрт оноож өгсөн нэр алдар”-ыг үзэх үзлийг хэлний нэгжүүдээс үүтгэн утгыг хөөн тайлбарлавал: Алдар гэх үгээс - алдар нэр гэх хоршоо үгийн утгыг эхийн хам сэдвээс тодруулан үзвэл “Эцэг эхээс төрөхөд оноож өгсөн дуудах үг” - *Алдар нэр хэн гэдэг вэ?* (Анаа мэргэн хаан), *олон түмэнд үнэлэгдэх байдал*”- *Миний* алдар нэр, намтар түүхийг сонсьё гэвэл цаад үлхээнцрүүдийн чинь хэн нь ч чамд хэлээд өгнө (Д.Мягмар. Газар бид хоёр), харин алдар гавьяа “сайн үйлс бүтээсний төлөө үнэлэгдэн түгсэн нэр” - Амьдралд хайртай түүний амиараа хамгаалсан газар, ах дүүгийн найрамдлын алдар гавьяа оршжээ (Ш.Дулмаа Нэргүй цэргийн булш), алдар гуншин “олонд дуудагдах нэр, цол” - Алдар гуншин шагналаа тэр дуртай улс нь аваг! (Д.Цоодол. Арван дөрөвт шүлгүүд), алдар суу, алдар цуу “сайн сайхнаар олонд түгсэн нэр” - Бусдын үрс адил алдар

суугаар мандаагүй (Д.Цоодол. Эхийн захидал), Манай энэ үед ажил хийсэн хүн л алдар цуутай сайн сайхан явна (Д.Норов. Цэцгийн гурван сар)", алдар хүнд "олны хүндэтгэл хүлээсэн нэр" - Гавьяа шагнал, алдар хүндэд ийм дуртай байсан гэж үү? (Д. Намсрай. Шагнал), алдар хэргэм "нэр хүнд болоод зэрэг дэв" - ...*жинхэнэ алдар хэргэм болж, өөрөө ч түүгээрээ бахархан энх тайвны уриалгад бүх нийтээр гарын үсэг зурахад "инжнаар Гүрсэд" гэж зурсан гэдэг...* (Ж.Лхагва. Зүрхний минь нийслэл)", алдар цол "гавьяа шагнал хүртэн олонд түгсэн нэр" - Алдар цол, гавьяа шагнал хүртэхээрээ боллоо (Д.Намсрай. Тооройн төгөл), Алдар нас "нэр болоод нас" - Алдар насыг баригч атхаг мэргэн хөөрхий (Монгол уртын дууны бичмэл цоморлиг - 2), Алдар ялалт "ялж дийлсэн нэр сүр" - Алдар ялалтын одон болж аж үйлдвэрүүд эгнээлэн зогслоо (Р.Чойном. Хүн) гэсэн ойролцоо боловч утга найруулгын ялгаатай хоршоо үгийн бүлэг үүссэн нь хэлний баримтаас тодорхой байна.

Харин нэр гэх үгээс - нэр алдар "Эцэг эхээс төрөхөд оноож өгсөн дуудах үг" - Нэр алдар хэн билээ? (Д.Намсрай. Цэцэгсийн нүүдэл), "Олонд түгсэн үнэ хүнд" - Хөлгүй нэр алдар, гоё үгээр өлсдөг (Д.Цоодол. Цаасан малгайн дууль), *нэр зар "олонд түгэх, цууд гарах, алдар хүнд" Гэтэл Галсанравжаагийн нас бие өсөж нутаг хошууны наадамд барилдаж эхлээд бараг наадам бүхэндээ түрүүг авч нэр зар нь нэмжээ* (МАЗ-ын тайлбарт дээж бичиг. Их монгол Шаравжамц), нэр зүс "оноосон алдар, царайны өнгө төрх" - Аян замын аяст нэр зүсээ үзэлцэн танилцсан байхыг үгүйсгэх аргагүй (Д.Гарамжаваас бичсэн захидал), нэр зэрэг "оноож өгсөн нэр ба албан тушаал" - *Засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүн, тайж, тавнангууд хэрэв гадаад улсад оргоор одох оргодлыг мэдсээр морь өгч унуулж илгээвээс өргөмжилсөн нэр зэргийг эвдэж, түүний албатыг татаж ав* (Хууль зүйн бичгүүд-1), нэр нөлөө "үнэ хүнд" - ...*нэр нөлөөг нь өсгөж авах нь чухал байлаа* (Ц.Түмэнбаяр. Тайган), нэр нүүр "олноо сайшаагдах үнэ хүнд" - Нэр нүүрийг чинь хугалах юм үнэндээ хийгээгүй (С.Удвал. Ховор хүн), нэр сүр "хүч нөлөө" - Нэр сүрнийхээ хэмжээгээр л том зантай байх юм шиг л бодож явсан юм болов уу даа (Ш.Сүрэнжав. Их хүний эгэл зан), нэр төр "алдар суу, үнэ хүнд" - Хамаг эрдмийг чинь сурсны буянд би нэр төртэй явна (Д.Цэнджав. Ёохор дарханы өв), нэр ус "оноож, бусдаас ялгаж өгсөн үг, харьяалал, төрсөн нутаг" - Тэр хүний нэр ус хүртэл Сүхцэрэнгийн санаанд тод байх бөгөөд ээж охин хоёрыг ивээн тэтгэх баатар эр Гангантөгс нэртэй баймаар ч юм шиг

санагдана (Д.Гармаа. Алдуурсан унага шиг бага нас), нэр хаяг "Хүн юмыг бусдаас ялгаж өгсөн үг, пайз" - Хэрвээ би монгол киноны хэн нэг өөр хүнтэй шууд харилцах нь дээр бол нэр хаягийг нь ирүүлээрэй (Л. Чойжилсүрэнд ирсэн захидал), нэр хоч "хүн юмсын олноос онцгой сайн муу шинжийн тодотгол" - Хараалчийн удам гэсэн нэр хоч, үг яриа насны гай болж... (Д.Цэнджав Хөх жавар), нэр хүнд "олноо өргөгдсөн үнэ цэн, эзлэх байр суурь, алдар" - Энэ бол нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай ажил гэж хэлээд хайгуулын цэг, зам маршрут тэмдэглэсэн дэлгэрэнгүй зураг гарган ширээн дээрээ дэлгэж билээ (Б.Догмид. Цамхагийн цагаан салхи), нэр цол "Алдар, хэргэм зэрэг, өргөмжилсөн үг" - *Анаа мэргэн хаан нэр цолоо дурдаж хэрэг зоригоо хэлжээ* (Анаа мэргэн хаан), "хочилж, муушаах утгаар" - ...*нэг зүйлийн муу нэр цолтой болгож...* (С.Буяннэмэх. Малчин Товуудай), нэр цуу "хотолд дуурсах алдар" - Мал сүргээ өсгөн үржүүлж нэр цуу нь мандаж яваа хүн (Д.Норов. Цэцгийн гурван сар), нэр ашиг "олз ашиг, хүндлэл" - Гурван ямхын хулсыг барьж эндүү ташаа бичих минь Гутал оймсыг бартал явж нэр ашгийг хөөхөөс дээр (Данзанравжаа. Зохиол бичих) гэсэн утга илэрхийлж байна.

"Нэр" гэдэг үгтэй хоршсон үг бүр тодорхой ойлголт ухагдахууныг илтгэж, утгын нарийн сүлжээ, авалцмал холбоогоор "нэр" хэмээх цогц мэдлэгийн гол цөм бүрэлддэг болохыг эрдэмтэн А. Цог-Очир "нэр ус – (нутаг), нэр алдар- (гавьяа хүндлэл), нэр төр - (ёслол, журам), нэр хүнд- (байр суурь), нэр сүр- (дуурсгал, сүлд), нэр нүүр- (эзэн бие), нэр хоч - (гооч), нэр төрөл- (ялгавар), нэр томьёо – (тэмдэг ухагдахуун)" хэмээн тайлбарласан байдаг.

Харин эдгээр баримтаас үзэхэд "алдар" гэдэг үг нь эерэг өнгө аястай, хүндэтгэлийн утгатай, тийм ч учраас "цол, хүнд, цуу, гавьяа, нэр" гэсэн үгтэй хоршиж хэрэглэгдэж байна. Зарим тохиолдолд нэрийг алдар орлох тул "алдар нэр, нэр алдар" гэх хоршоо үгс байраа чөлөөтэй сэлгэн, нэг ижил утгаар орж байна. Гэтэл "алдар гавьяа, алдар хэргэм" гэсэн хоршоо үг бүтэж байхад "нэр гавьяа, нэр хэргэм" гэж хорших нь бараг үгүй. Мөн эдгээр хоршоо үгийн хэрэглэгдэж байгаа утга үүргээс харахад эхийн өнгө аяс, зохиолч, бичигчийн үгийн сангаас шалтгаалан мөр тэгшлэх, толгой холбох, авианы найруулгатай холбоотой бүтэж байгаа сонин содон үгс байгааг ч үгүйсгэхгүй. Гэвч "алдар", "нэр" гэсэн үгсээс түүний үндэстний шинж төрхийг илэрхийлсэн дээрх нийлмэл үг үүссэн нь тодорхой юм. Дээр өгүүлсэнчлэн хэл нь харилцах, мэдээлэх, нөлөөлөх үүрэгтэйгээс гадна хүний хүрч мэдэрсэн бодит ертөнцийн талаарх мэдлэгийг

тусган авч хуримтлуулан хадгалж байдгаас үүдэн монгол хүн “нэр”- ээ ихэд хайрлаж, хичээдэг мөн чанартай болох нь илэрхий байна.

Мөн хэлний баримтаас ажиглахад нэр нь “төр, нүүр, зүс, хоч, хаяг, зар, сүр” зэрэг үгтэй хоршиж байгаагаараа АЛДАР-аас ялгагдаж байна. Хүн төрж мэндэлсэн газар устайгаа амин холбоотой, төр улсдаа нэрээрээ харьяалагдаж, хүмүүн биеийг төлөөлдөг учраас нүүр зүстэйгээ ханьсаж байгаа хэрэг. Тийм ч учраас монголчууд “хүний газар нэрээ өөрийн газар ясаа” гэсэн зүйр цэцэн үг хэлдэг. Энэ нь таны нэр сэвтвэл унасан газар, угаасан ус чинь сэвтэнэ, таны нэр алдаршвал газар ус тань алдаршина гэсэн сэтгэлгээний гүн ухаарал тодорч байна. Нөгөө талаас “Төрдөө нэртэй түмэндээ алдартай яв” гэсэн сургаал үгэнд өнөө л төрд таны нэр бүртгэлтэй

байгаагийн баталгаа, “Нэртэй айлын зүстэй хүү” гэхэд өсөж төрсөн гэр орны чинь нэр сүрийг та тээж яваа гэсэн санаа тодорч байна. Зүсийг нүүрээр тодорхойлдог. Хоч бол хүний албан ёсны бус хоёр дахь нэр юм. Тухайн хүний (голдуу хүүхдийн) нэрийг цээрлэх, эерүүлэх, хүндэтгэх, эсвэл өхөөрдөх, энхрийлэх, дооглох, доромжлох, шоглох, шоовдорлох зэрэг шалтгаанаар хоч нэр өгдөг. Тиймээс “нэр хоч” гэсэн хоёр үг хоршиж хэрэглэгдэж, харин “зар” гэдэг үг “нэр” гэдэг үгтэй хоршихоороо сөрөг өнгө аястай болдог. “Зар” гэдэг үг нь энэ тохиолдолд “цуу” гэдэг үгтэй эсрэг утгатай хэрэглэгдэнэ. Энэ бүхнээс “нэр зар, нэр цуу, алдар цуу” гэсэн хоршоо үгсийн утгыг харьцуулбал утга, өнгө аяс, найруулгын ялгаа тодорхой харагдаж байна.

3. “Нэр, алдар” гэх хоёр үгийн утгын ялгаа, найруулгын өнгө аясыг ямар үйл үгтэй холбогдож байгаагаар тодруулан үзвэл:

а). алдарт хүрэх  
алдар хүртэх  
алдарт тэмүүлэх  
алдрыг хүсэх  
алдраар бахархах  
алдар нь хүнддэх  
алдрын титэм  
алдарын бариа  
алдартай болох  
алдрын оргил, орой

Нэрийн хүндэтгэл утгаар хэрэглэгдэх боловч “гавьяа”, “хүндлэл” гэсэн утга давамгайлдаг онцлог буй. Танихуйн зүйрлэлийн үүднээс ерөнхийдөө “УУЛ”-тай зүйрлэсэн байдаг нь уулыг эрхэмлэх үзэлтэй холбоотой боловч цаанаа уулын оройд гарахтай нэр хүндтэй болж, алдар хүндийн суудалд суух зэргийг адилтган үзэх болсон нь орон зайн баримжааны зүйрлэлээс улбаатай байдаг.

б). нэр өгөх  
нэр хайрлах  
нэр хиртэх  
нэр цэвэрлэх  
нэрээ хайрлах  
нэр сэвтэх  
нэр олох  
нэрээ бодох  
нэрээ алдах  
нэр хичээх

Үгийн сангийн үндсэн утгаа буюу олноос ялгаж дуудахаар оноож хайрласан тусгай “нэрийдэл” хэмээх утгаар хэрэглэгддэг, ариун чанартай, шулуун цэх шинжийг агуулсан байдаг.

Ийнхүү алдар нэр хэмээх үгсийн утгын холбоо хамаарлаас үзэхэд монгол хүний нэрээ хичээж хайрлаж явах нь тухайн хүний ёс суртахуунтай холбоотой болох нь ажиглагдаж байна.

Өөрөөр хэлбэл “хүн байх чанар”-ын ил далд шинжүүдийг НЭР-д хамаатуулж, утгын холбоогоор хийсвэрлэн сэтгэж адилтгасан байна. Хүний мөн чанар, ёс зүйтэй харьцсан туршлага нь сурвалж хүрээний буюу суурь мэдлэг болж

байна.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд, сурвалж ба зорилгын хүрээний хооронд нийтлэг орны шинжүүд нэвт үйлчилж, мэдээллийн орны сүлжээнд шинэ нэгдлийг үүсгэсэн нь утгаа зорилгын хүрээн дэх (target domain) концептуал бүтцийг бодит ертөнцийн танилт, туршлагаар сэтгэн ухаарч илэрхийлсний үр дүн болно. Хүн байх чанар, хүний мөн чанараа алдахгүйг

хичээдэгтэй адил НЭР-ээ хайрлаж хичээдэг, сэвтээхгүйг хичээн явдагтай адилтгасан байна. Үүнээс "НЭР БОЛ БИЕ ЮМ, НЭР БОЛ ЁС СУРТАХУУН ЮМ" гэсэн танихуйн хийсвэр утга илэрч байна. Нэр төртэй амьдрал хүнийг алдар хүндтэй болгодог. Энэ утгаараа "нэр бол бие юм" гэх хийсвэр утгын илэрхийлэл болж байна.

Монгол хүн "нэр" – ээ ихэд эрхэмлэн хичээж, сэвтүүлэхгүй авч явах нь хүний ёс суртахуун, хүн байх чанартай салшгүй холбоотойгоос гадна монгол хүний нэр үргэлж нутаг устайгаа хамт нь байдаг гэсэн нэгэн өвөрмөц хэв шинж тодорч байна. Нөгөө талаас хүний нэр өөрийнх нь төлөөлөл болдог. Өөрөөр хэлбэл "нэр бол бие юм, нэр бол ёс суртахуун юм" гэсэн танихуйн хийсвэр утга илэрч байна. Харин "алдар" нь нэрийн хүндэтгэл утгаар хэрэглэгдэх боловч "гавьяа", "хүндлэл" гэсэн утга давамгайлдаг онцлогтой байна. Энэ бүхний цаана монгол хүний хүн болох ерөнхий үзэл илэрч байна. Энэ бүхнээс хэлний боломж нь хүний танихуйн ерөнхий нөөцөд тулгуурладаг болохоос хэлний тусгай загвар биш гэдэг нь илэрхий байна.

#### Ашигласан материал

- Zalsang. Monggol u2seg-u2n bu2gu2de tailburi bic4ig. U1bu2r monggol arad-un heblel-u2n qoriy-a.
- Fauconnier (1994, 1996, 1997) *Cognitive Linguistics Basic reading*, Editor Dirk Geeraerts, Mouton de Gruyter Berlin, New York 2006.
- Болд, Л. (2008) . Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Улаанбаатар. А-Г, XXXX+1-590+х
- Болд, Л. (2008) . Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Улаанбаатар. М-С, XXXX+1177-1858+х
- Бямбасан, П. (1975). ОЦМХ-ний үгийн бүтэц. Нэр үгийн аймаг. Улаанбаатар
- Бямбасан, П. (1975). ОЦМХ-ний үгийн бүтэц. Нэр үгийн аймаг. Улаанбаатар
- Мижиддорж, Л. (1976,4). Манж монгол хэлний харьцаа. Улаанбаатар
- Монгол хэлний тайлбар толь бичиг. (2011). Монсудар, Монгол хэл соёл, Улаанбаатар. XVI+1-1239
- Монгол хэлний хоршоо үгийн толь. (2013). Монсудар, Монгол хэл соёл, 9, Улаанбаатар
- Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг. (2009). Монсудар, Улаанбаатар. XVI+1-1062
- Нансалмаа, Н., Долгор, С. (2014). Танихуйн хэлшинжлэл. Улаанбаатар
- Норжин. (1999). Монгол хэлний толь. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Норжинлхам, С. (1999), ОЦМХ-үүдийн хоршоо үгийн үгийн сан, хэлзүйн онцлог. Улаанбаатар
- Норжинлхам, С. (1999). Орчин цагийн монгол хэлнүүдийн хоршоо үгийн үгийн сан, хэлзүйн онцлог. Улаан-Үд
- Одонтөр, Ш., Баттөгс, М., (2013). Монгол хэлний гучтын тайлбар толь II, Улаанбаатар.992
- Өнөрбаян.Ц., (2004), Орчин цагийн монгол хэлний үг зүй. Улаанбаатар
- Ринчен. Б., (1967). Монгол бичгийн хэлний зүй. Өгүүлбэр зүй. Улаанбаатар
- Ринчен. Б., (2015). Монгол бичгийн хэлний зүй. Дөрөвдүгээр боть. Өгүүлбэр зүй. Улаанбаатар
- Сарангэрэл, Р. (2016). Монгол хэлний хоршоо үгийн бүтэц, утгын судалгаа. Нэг сэдэвт бүтээл Улаанбаатар
- Цог-Очир. (2015). Эх хэлний хэлзүйн байгуулалд туссан монгол хүний сэтгэлгээний онцлог. ЭШБ. 2015. №02. Улаанбаатар
- Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар
- Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар